



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сайншанд сумын Хотын захирагчийн ажлын албаны 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2024/76/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Дорноговь аймаг 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 70522734 Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 70523020 Ахлах аудитор: О.Нарангарав Цахим хаяг: narangaravo@audit.gov.mn	Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn
---	--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.Аудитын санал дүгнэлт

 ДОРНОГОВЬ АЙМАГ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гууламж, 3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103, Утас: (976) 7052 2734 Цахим хуудас: dorngovi@audit.gov.mn <u>2024.02.23</u> № <u>1-6/54</u> танай _____-ны № _____-т	САЙНШАНД СУМЫН ХОТЫН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА Т.ОТГОНБАЯР ТАНАА
Өөрчлөлтгүй дүгнэлт	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сайншанд сумын Хотын захирагчийн ажлын албаны 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.</p> <p>Сайншанд сумын Хотын захирагчийн ажлын албаны 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.</p>	
Дүгнэлтийн үндэслэл	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p>	
Асуудлыг онцолсон хэсэг	
<p>Сайншанд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 11/05 дугаар тогтоолоор "Тохижилт-Сайншанд" хотын тохижилтын газрыг 2022 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр тасалбар болгон татан буулгаж, чиг үүргийг Сайншанд сумын Хотын захирагчийн ажлын албанд шилсэнтэй холбоотой тухайн байгууллагын 2022 оны санхүүгийн тайлангаарх 4,888.0 сая төгрөгийн үлдэгдэл хөрөнгийг нэмж бүртгэн тайлагнасан байна.</p>	
Аудитын гол асуудал	
<p>1. Байгууллагын шилэн дансанд байршуулвал зохих 3,892.6 сая төгрөгийн 183 мэдээллээс 738.6 сая төгрөгийн 46 мэдээллийг хугацаа хоцроон байршуулж, 2,108.4 сая төгрөгийн 95 мэдээллийг байршуулаагүй байна. Мэдээлэл байршуулсан хэрэгжилт 52.9%-тай, хугацаа хоцролт 85%-тай байна.</p>	
010020207	

2. Тайлант онд Шунхлай ХХК-аас нийт 446.4 сая төгрөгийн шатахууныг төсвийн хөрөнгөөр худалдан авахдаа худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй шууд худалдан авалт хийсэн байна.

3. Тайлант оны батлагдсан төсвийн цалингийн зардлаас 2.7 сая төгрөгийг ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд, урсгал засварын зардлаас 22.0 сая төгрөгийг тээвэр шатахууны зардалд, бусдаар гүйцэтгүүлэх бусад НАҮТХ-ийн зардлаас 0.5 сая төгрөгийг аудитын баталгаажуулалтын зардалд, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас 1.0 сая төгрөгийг шуудан холбооны зардалд тус тус зориулалт бусаар зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Сайншанд сумын Хотын захирагчийн ажлын алба нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 04/14 дугаар албан бичгээр, залруулсан санхүүгийн тайланг 2024 оны 02 дугаар сарын 23-ны 04/28 дугаар албан бичгээр тус тус ирүүлсэн болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.ГАН-ӨЛЗИЙ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	11,001,690.00	642,338,388.87
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	4,223,444.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	4,223,444.00
3121	Төгрөг	-	4,223,444.00
31211	Төрийн сангийн харилцах	-	4,223,444.00
33	АВЛАГА	266,492.00	994,831.31
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	428,339.31
335	Бусад авлага	266,492.00	566,492.00
3351	Байгууллагаас авах авлага	266,492.00	566,492.00
35	БАРАА МАТЕРИАЛ	10,735,198.00	637,120,113.56
351	Түүхий эд материал	-	346,130.00
35130	Эм боох материал	-	346,130.00
354	Хангамжийн материал	10,735,198.00	636,773,983.56
35410	Бичиг хэргийн материал	8,665,100.00	12,451,920.00
35420	Аж ахуйн материал	2,019,698.00	553,486,609.56
35430	Сэлбэг хэрэгсэл	-	62,120,454.00
35440	Түлш, шатах тослох материал	50,400.00	8,635,000.00
35460	Хүнсний материал	-	80,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	153,736,560.98	5,010,589,426.67
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	153,736,560.98	5,010,589,426.67
392	Биет хөрөнгө	153,494,560.93	4,997,027,509.62
39201	Барилга, байгууламж, орон сууц	-	418,496,248.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	(86,004,246.59)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	-	2,335,171,316.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-	(1,376,211,857.98)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	22,574,275.00	68,404,990.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(2,769,943.34)	(37,778,220.11)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,264,500.00	27,474,779.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(797,074.51)	(7,118,139.33)
39214	Бусад үндсэн хөрөнгө	139,176,084.00	7,645,194,011.16
39215	Хуримтлагдсан элэгдэл	(5,953,280.22)	(3,990,601,370.53)
393	Биет бус хөрөнгө	242,000.05	13,561,917.05
39301	Програм хангамж	352,000.00	2,299,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(109,999.95)	(2,001,082.95)
39303	Бусад биет бус хөрөнгө	-	13,264,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	164,738,250.98	5,652,927,815.54
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	73,346.00	1,318,105.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	73,346.00	1,318,105.00
413	Өглөг	73,346.00	1,318,105.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	73,346.00	1,318,105.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	164,664,904.98	5,651,609,710.54
51	Засгийн газрын хувь оролцоо	164,664,904.98	5,651,609,710.54
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	-	2,313,537,678.87
51101	Өмч: - төрийн	-	2,313,537,678.87
512	Хуримтлагдсан үр дүн	164,664,904.98	3,169,301,374.11
51210	Өмнөх үеийн үр дүн	164,664,904.98	2,570,337,793.69
51220	Тайлант үеийн үр дүн	-	598,963,580.42
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	-	168,770,657.56
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	164,738,250.98	5,652,927,815.54

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	257,571,722.61	4,319,240,603.73
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	73,159,788.00	1,436,807,964.00
120	Нийтлэг татварын бус орлого	73,159,788.00	1,436,807,964.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,292,898.00	63,642,766.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,292,898.00	57,424,566.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	6,218,200.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Үндсэн хөрөнгө	64,866,890.00	1,102,981,615.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Бараа материал		270,183,583.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	184,411,934.61	2,882,432,639.73
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	85,211,934.61	2,882,432,639.73
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	85,211,934.61	2,882,432,639.73
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	191,694,797.07	3,720,277,023.31
21	УРСГАЛ ЗАРДАЛ	191,694,797.07	3,720,277,023.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	191,694,797.07	3,707,425,683.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	61,014,992.11	1,537,727,538.69
210101	Үндсэн цалин	51,986,612.03	727,949,599.91
210102	Нэмэгдэл	5,352,389.08	611,343,305.87
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,420,000.00	156,344,416.50
210104	Урамшуулал	1,255,991.00	42,090,216.41
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,863,156.50	184,135,220.28
210201	Тэтгэврийн даатгал	7,676,269.67	146,037,163.91
210202	Тэтгэмжийн даатгал	720,835.25	5,094,979.62
210203	ҮОМШӨ-ний даатгал	391,070.13	5,190,342.99
210204	Ажилгүйдлийн даатгал	97,308.26	1,942,553.90
210205	Эрүүл мэндийн даатгал	977,673.19	25,870,179.86
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	23,033,668.22
210301	Гэрэл, цахилгаан	-	506,000.00
210302	Түлш, халаалт	-	21,304,538.22
210303	Цэвэр, бохир ус	-	1,223,130.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,641,330.00	479,947,873.00
210401	Бичиг хэрэг	529,850.00	9,942,480.00
210402	Тээвэр, шатахуун	2,311,000.00	90,058,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	153,780.00	1,547,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	376,847,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,710,700.00	1,552,993.00
2105	Нормативт зардал	-	66,320.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	66,320.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,646,300.00	290,938,162.85
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	5,440,070.80
210604	Урсгал засвар	1,646,300.00	285,498,092.05
2107	Томилолт, зочны зардал	-	32,000.00
210702	Дотоод албан томилолт	-	32,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	108,970,400.00	274,908,703.81
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	108,970,400.00	261,358,632.81
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	1,008,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	9,992,665.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	1,500,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	593,890.00
210807	Газрын төлбөр	-	455,516.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	558,618.46	916,636,196.46
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	1,674,281.42
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	558,618.46	914,961,915.04
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	12,851,340.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	12,851,340.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	12,851,340.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	65,876,925.54	598,963,580.42
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	65,872,550.49	598,963,580.42

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	205,108,224.61	2,947,947,141.73
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,292,898.00	64,948,010.00
120	Нийтлэг татварын бус орлого	8,292,898.00	64,948,010.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,292,898.00	64,948,010.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,292,898.00	57,424,566.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих		6,205,339.00
1200047	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө		1,318,105.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	196,815,326.61	2,882,999,131.73
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	111,603,392.00	566,492.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	12,403,392.00	566,492.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	85,211,934.61	2,882,432,639.73
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	85,211,934.61	2,882,432,639.73
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	204,841,732.61	2,908,367,097.73
21	УРСГАЛ ЗАРДАЛ	204,841,732.61	2,908,367,097.73
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	204,841,732.61	2,894,949,265.73
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	65,217,048.59	1,541,009,660.40
210101	Үндсэн цалин	52,889,875.57	731,231,721.62
210102	Нэмэгдэл	4,592,351.02	611,343,305.87
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,604,000.00	156,344,416.50
210104	Урамшуулал	4,130,822.00	42,090,216.41
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,322,016.19	181,354,783.88
210201	Тэтгэврийн даатгал	5,673,900.27	143,256,727.51
210202	Тэтгэмжийн даатгал	662,692.00	5,094,979.62
210203	ҮОМШӨ-ний даатгал	529,853.62	5,190,342.99
210204	Ажилгүйдлийн даатгал	130,286.74	1,942,553.90
210205	Эрүүл мэндийн даатгал	1,325,283.56	25,870,179.86
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	23,227,268.22
210301	Гэрэл, цахилгаан	-	506,000.00
210302	Түлш, халаалт	-	20,007,968.22
210303	Цэвэр, бохир ус	-	2,713,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,066,030.00	456,347,203.00
210401	Бичиг хэрэг	1,691,800.00	5,499,250.00
210402	Тээвэр, шатахуун	2,111,400.00	140,246,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	153,780.00	1,520,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	306,215,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	109,050.00	2,865,953.00
2105	Нормативт зардал	-	32,957,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	32,957,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,971,300.00	357,905,516.75
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	10,556,200.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	15,436,200.00
210604	Урсгал засвар	9,971,300.00	331,913,116.75
2107	Томилолт, зочны зардал	-	32,000.00
210702	Дотоод албан томилолт	-	32,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	117,265,337.83	298,678,202.06
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	117,265,337.83	285,636,131.06
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	9,992,665.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	1,500,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	593,890.00
210807	Газрын төлбөр	-	455,516.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	3,437,131.42
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	3,437,131.42
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	13,417,832.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	12,851,340.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	12,851,340.00

Сайншанд сумын Хотын захирагчийн ажлын албаны 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	566,492.00
213405	нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		566,492.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>266,492.00</u>	<u>39,580,044.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	35,356,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	35,356,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	35,356,600.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	35,356,600.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-</u>	<u>(35,356,600.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	266,492.00	4,223,444.00
10	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	4,223,444.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	98,792,354.49	98,792,354.49
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	65,872,550.49	65,872,550.49
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	164,664,904.98	164,664,904.98
2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	164,664,904.98	164,664,904.98
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	2,405,672,888.71	2,405,672,888.71
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	168,770,657.56	-	168,770,657.56
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	2,313,537,678.87	-	-	2,313,537,678.87
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	598,963,580.42	598,963,580.42
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,313,537,678.87	168,770,657.56	3,169,301,374.11	5,651,609,710.54

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,300,112,600.00	2,939,857,205.73
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,300,112,600.00	2,939,857,205.73
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,289,361,200.00	2,929,105,865.73
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,683,900,800.00	1,541,009,660.40
210101	Үндсэн цалин	899,278,000.00	731,231,721.62
210102	Нэмэгдэл	666,350,800.00	611,343,305.87
210103	Унаа хоолны хөнгөлөлт	118,272,000.00	156,344,416.50
210104	Урамшуулал	-	42,090,216.41
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	244,165,500.00	181,354,783.88
210201	Тэтгэврийн даатгал	176,789,800.00	143,256,727.51
210202	Тэтгэмжийн даатгал	16,843,900.00	5,094,979.62
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,475,200.00	5,190,342.99
210204	Ажилгүйдлийн даатгал	3,368,700.00	1,942,553.90
210205	Эрүүл мэндийн даатгал	33,687,900.00	25,870,179.86
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,478,600.00	23,227,268.22
210301	Гэрэл, цахилгаан	1,518,600.00	506,000.00
210302	Түлш, халаалт	27,000,000.00	20,007,968.22
210303	Цэвэр, бохир ус	2,960,000.00	2,713,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	508,500,000.00	456,481,203.00
210401	Бичиг хэрэг	5,500,000.00	5,499,250.00
210402	Тээвэр, шатахуун	154,000,000.00	140,246,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,000,000.00	1,520,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	344,000,000.00	306,215,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,000,000.00	2,999,953.00
2105	Нормативт зардал	33,000,000.00	32,957,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	33,000,000.00	32,957,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	393,748,600.00	393,065,316.75
210601	Багаж, техник, хэрэгсэл	24,000,000.00	23,992,000.00
210602	Тавилга	10,000,000.00	10,000,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	15,500,000.00	15,436,200.00
210604	Урсгал засвар	344,248,600.00	343,637,116.75
2107	Томилолт, зочны зардал	1,500,000.00	32,000.00
210702	Дотоод албан томилолт	1,500,000.00	32,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	389,567,700.00	297,478,202.06
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	376,357,000.00	284,436,131.06
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	10,000,000.00	9,992,665.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,500,000.00	1,500,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	750,000.00	593,890.00
210807	Газрын төлбөр	460,700.00	455,516.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,500,000.00	3,499,931.42
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,500,000.00	3,499,931.42
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,751,400.00	10,751,340.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,751,400.00	10,751,340.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,751,400.00	10,751,340.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,300,112,600.00	2,939,857,205.73

1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,276,112,600.00	2,882,432,639.73
132001	Орон нутгийн төсвөөс	3,276,112,600.00	2,882,432,639.73
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	24,000,000.00	57,424,566.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	24,000,000.00	57,424,566.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	110.00	96.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	16.00	16.00
620003	Үйлчлэх ажилтан	93.00	79.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	566,492.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	566,492.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	566,492.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	566,492.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	566,492.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	566,492.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	566,492.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	566,492.00

2.7 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,300,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,300,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,200,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,200,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,200,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,100,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,100,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,100,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	7,523,444.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,523,444.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,523,444.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,223,444.00

3. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 4,938.5 сая төгрөгийн 5 алдаа зөрчил илэрснээс, аудитын явцад 4,903.1 сая төгрөгийн 2 алдааг залруулж, залруулагдаагүй 35.4 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага өгсөн.

Аудитын явцад залруулсан алдаа:

1. Санхүүгийн тайланг тулган баталгаажуулахад 4,895.5 сая төгрөгийн алдаа гарлаа. Үүнд: - 2023 оны 1 сараас СШ-ЗАА-д, СШ Тохижилтыг нийлүүлж балансыг нэгтгэхэд бүртгэлд Тохижилтын 2022 оны балансын мөнгөн хөрөнгийн 6.2 сая төгрөг, 0.3 сая төгрөгийн авлага, цэвэр хөрөнгийн өмчийн 4,888.0 сая төгрөгийн үлдэгдлийг бүртгэж аваагүй,

- Цалингийн гүйлгээний буцсан гүйлгээний 1.3 сая төгрөгийн орлогыг орлогоор бүртгэж, цалингийн зардлыг бууруулаагүй зэрэг алдааг залруулав.

2. Цалингийн тооцооны хүснэгтээс бодогдсон цалин, суутгалын дүнг сар бүрээр шүүж, шилжүүлсэн дүн, санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн зардал зэрэгтэй тулган үзэхэд цалингийн зардлыг 4.8 сая төгрөгөөр илүү, АО-НДШ-ийг 2.7 сая төгрөгөөр дутуу бүртгэсэн тайлагнасныг залруулав.

5.1 Албан шаардлага

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

НББ-ийн бүртгэл хөтлөлт, дансны харьцааг шалгахад цалингийн зардлаас 2.7 сая төгрөгийг ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд, урсгал засварын зардлаас 22.0 сая төгрөгийг тээвэр шатахууны зардалд, бусдаар гүйцэтгүүлэх бусад НАҮТХ-ийн зардлаас 0.5 сая төгрөгийг аудитын баталгаажуулалтын зардалд, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас 1.0 сая төгрөгийг шуудан холбооны зардалд тус тус зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай” журамтай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн албан шаардлага:

Батлагдсан төсвийн зардал, хөтөлбөр арга хэмжээний зардлыг зориулалт бусаар зарцуулахгүй байх

2. Хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагын шилэн дансны сайтад байршуулбал зохих 3,862.6 сая төгрөгийн 183 мэдээллээс 738.6 сая төгрөгийн 46 мэдээллийг хугацаа хоцроон байршуулж, 2,108.4 сая төгрөгийн 95 мэдээллийг байршуулаагүй байна. Мэдээлэл байршуулсан хэрэгжилт 52.9%-тай, хугацаа хоцролт 85%-тай байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1 “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай” журамтай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн албан шаардлага:

Шилэн дансны сайтад байршуулбал зохих мэдээллийг цаг хугацаанд нь байршуулж байх

3. Хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд Шунхлай ХХК-аас нийт 446.4 сая төгрөгийн шатахууныг төсвийн хөрөнгөөр худалдан авсан боловч худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1 “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1 “Улсын болон орон нутгийн төсвөөс хөрөнгө оруулалтаас бусад зардалд хуваарилсан хөрөнгө, бусад эх үүсвэр, түүнчлэн өөрийн хөрөнгөөр санхүүжигдэх бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг захиалагч энэ хуульд заасан журмын дагуу зохион байгуулна”, “Босго үнэ шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол зэрэгтэй тус тус нийцэхгүй байна.

Өгсөн албан шаардлага:

Цаашид төсвийн хөрөнгөөр худалдан авалт хийхдээ холбогдох заавар журмыг мөрдөн ажиллах

Дээрх албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
НББ-ийг буруу бүртгэсэн	1	4,805,504.7	-	-	1	4,805,504.7	1	4,805,504.7	-	-	-	-
Цалингийн зардлыг буруу бүртгэсэн	1	7,594.7			1	7,594.7	1	7,594.7				
Дүн	2	4,903,099.4	-	-	2	4,903,099.4	2	4,903,099.4	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Зардлыг зориулалт бусаар зарцуулсан	1	26,301.9	-	-	1	26,301.9	-	-	-	-	-	-
Дүн	1	26,301.9	-	-	1	26,301.9	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй	1	-	-	-	1	-	-	-	-	-
Дүн	1	-	-	-	1	-	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
ТБОНӨХБАҮХАТ хуулийн зөрчин шууд худалдан авалт хийсэн	1	-	-	-	1	-	-	-	-	-
Дүн	1	-	-	-	1	-	-	-	-	-
Нийт дүн	2	-	-	-	2	-	-	-	-	-

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			